



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/92

Өвт

Тамхи худалдах тусгай зөвшөөрөл  
сунгах тухай

Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 7.3 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 16 дугаар зүйлийн 16.3.4, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Н.Өлзийбаяр эзэнтэй “Өөдрөг”, Г.Эрдэнэчимэг эзэнтэй “Хишиг буян”, Н.Болдбат эзэнтэй “Мөнх-хайрхан”, Д.Түвшинтөгс эзэнтэй “Арвинжаргал” П.Анхбаатар эзэнтэй “Амт”, А.Бямбацэцэг эзэнтэй “Баялаг”, Д.Жамъяндагва эзэнтэй “Оч”, С.Нямлхагва эзэнтэй “Дүүрэн баясах” А.Эрдэнэ-Очир эзэнтэй “Нийл”, Н.Дэлгэрмаа эзэнтэй “Мөнхдэлгэрэх”, Д.Пүрэвтогтох “Сөн далай” хүнсний дэлгүүрүүдийн тамхи худалдах тусгай зөвшөөрлийн хугацааг 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдрөөс 2 жилийн хугацаатай сунгасугай.

2. Тамхи худалдаалах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамж 100000 (Нэг зуун мянган) төгрөгийг сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэхийг Гааль, татварын улсын байцаагч (Н.Батсайхан)-д даалгасугай.

3. Тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгогдсон дэлгүүрийн үйл ажиллагаанд хяналт тавьж үр дүнг тооцон ажиллахыг Цагдаагийн хэсгийн дарга, (Д.Энх-Амгалан Цагдаагийн ахмад), Гааль, татварын улсын байцаагч (Н.Батсайхан), Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтний албан тушаалыг түр орлон гүйцэтгэгч (М.Мягмаржав) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН



822201183

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/